

МОНГОЛ УЛС БОЛОН ХЯТАДЫН ӨМӨЗО-НЫ ХООРОНДОХ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

*Н.Улаан-Од**

I. Монгол Улс болон Өвөр Монголын Өөртөө Засах Орны эдийн засгийн хамтын ажиллагааны тойм байдал

Монгол Улс болон ӨМӨЗО-ны хоорондох хил худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 1983 онд эхлэн 1989 оноос эрчимтэй өрнүүлсэн юм. Энэхүү хамтын ажиллагааг өрнүүлсэн явдал нь Монгол Улс, БНХАУ-ын хоорондох найрсаг харилцааг сайжруулах, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлэх үйлсэд ач холбогдол өгсөн төдийгүй ӨМӨЗО-ны эдийн засгийг сэргээн хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн юм. Сүүлийн жилүүдэд хоёр талын хүчин чармайлтаар хил худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байна.

1. Хил худалдаа: ӨМӨЗО, Монгол Улсын хоорондох худалдааны эргэлт 2004 онд /урьдчилсан дүнгээр/ 250 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оноос 7.7 хувиар нэмэгдэж, үүний дотор экспортын хэмжээ 70.1 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 10 хувиар, импортын хэмжээ 170 сая ам.долларт хүрсэн нь¹ өнгөрсөн оныхоос 5 хувиар тус тус нэмэгджээ. ӨМӨЗО-ноос экспортлож байгаа барааны төрөлд голдуу машин техник, цахилгаан бараа, сэлбэг, хуванцар эдлэл, бэлэн хувцас, нэхмэл эдлэл, хүнсний бүтээгдэхүүн, Монгол Улсаас ӨМӨЗО-д боловсруулсан малын арьс шир, ноолуур, хаягдмал төмөр, ямааны ноолуур, хивс зэрэг бараа хамаарагдаж байна.

Экспорт, импортын хэмжээнээс харахад импортын хэмжээ экспортын хэмжээнээс их байна. Экспорт, импортын бүтцээс авч үзвэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ давуу байртай байж, сүлжмэл эдлэл, хүнсний ногоо, цагаан будаа нь хил худалдааны экспортын гол нэр төрлийн бараа болжээ. Оюуны өндөр бүтээмжтэй цахим болон цахилгаан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Экспортын барааны бүтцийн хувиралт нэг их биш, мөн л түүхий эд голлож байна. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдааны хэмжээ 2003 онд 448.7 сая ам.долларт хүрсэн бөгөөд хоёр улсын нийт худалдааны 46 хувийг ӨМӨЗО-той хийсэн худалдаа эзэлж байна.

2. Эдийн засгийн хамтын ажиллагаа: ӨМӨЗО болон Монгол Улсын хооронд барилга байгууламж барих, хүнсний ногоо тарих, ажиллах хүч гаргах зэрэг хамтын ажиллагаа өргөжихийн зэрэгцээ эрчим

¹Н.Улаан-Од - Өвөр Монголын Их сургуулийн Хөрш орон судлах хүрээлэнгийн судлаач

хүч, дулааны энерги, барилгын материал, уул уурхай, ноос ноолуур, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах салбарт ч нягт хамтран ажиллаж байна. 2003 оны эцсийн байдлаар ӨМӨЗО болон Монгол Улсын хооронд барилга барих, ажиллах хүч гаргах, геологи хайгуулийн ажил хийх зэрэг 355 төслийн гэрээ хийгдэж, гэрээнд хийгдсэн худалдааны хэмжээ 152.9 сая² ам.доллар, биелэлтийн хэмжээ 77.8 сая ам.долларт хүрч, ажиллах хүчний хэмжээ 7167 хүн³ удаад хүрчээ. 2004 онд ӨМӨЗО болон Монгол Улс нь ямааны ноолуур боловсруулах салбарт хамтран ажиллахын сацуу уул уурхайн салбарт хамтын ажиллагаа өрнүүлэхээр төлөвлөж байна.

Өвөр Монголын Чинхуа корпораци Монголын Улсын Нарийн сухайтын нүүрсний уурхайг, Бугатын болд төмрийн үйлдвэр нь Монгол Улсын Төмөртийн уурхайг нээн ашиглахаар гэрээ хэлцэл хийж байна. 2003 оны дүнгээр ӨМӨЗО-ноос нийт 20 гаруй аж ахуйн нэгж Монголд 6.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр бүртгэгдэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бол Монгол Улсаас ӨМӨЗО-нд 24 аж ахуйн нэгж 2.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. 1989 оноос хойш ӨМӨЗО болон Монгол Улсын хооронд ажиллах хүч гаргах 294 гэрээ байгуулж уг гэрээнд 124 сая ам.долларын ажил тусгагдсан бөгөөд үүний 58 сая ам.доллартай тэнцэх ажлыг гүйцэтгэж, 5118 хүнийг томилон ажлуулж, Монгол Улсын эдийн засгийн салбарт 8 төслийг ӨМӨЗО хариуцан хийж, энэ төсөлд зарцуулагдах хөрөнгө 8.7 сая ам.долларт хүрч, хөрөнгө оруулалтын төслүүдэд ӨМӨЗО-ны талаас оруулсан хөрөнгийн хэмжээ 5.4 сая ам.доллар болсон байна.

ӨМӨЗО болон Монгол Улсын хооронд Эрээн, Хөх хот (агаарын), Ганц мод, Зүүнхатавч, Архашаат зэрэг улсын дэсийн боомт, Чэхэ, Мандал, Аршаан, Өвдөг зэрэг мужийн дэсийн 4 боомтыг нээн ажиллуулж байна. Энэ жил Зүүнхатавч боомтыг Олон улсын чанартай байнгын нээлттэй, Чэхэ-Шивээхүрээ боомтыг байнгын нээлттэй боомт болгохоор тохиролцсон байна.

II. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд харилцан айлчилж ирсэн тойм байдал

Наяад оны сүүлч үеэр хоёр талын харилцан айлчилж байсан хүмүүс нь зөвхөн худалдааны мэргэжлийн хүмүүсийн түвшинд байсан бол сүүлийн жилүүдэд дээд зиндааны удирдах хүмүүсийн хэмжээнд хүртэл өндөржиж худалдаа эдийн засгийн талаар хамтран ажиллах олон арга хэмжээг зохиож байна. Үүнд 1995 оны 7 сард хоёр тал нь /дэд сайдын зиндааны/ “Худалдаа, эдийн засаг техникийн хамтын ажиллагааны байнгын зөвлөлдөх ажлын хэсэг”-ийг байгуулж, 10-р сард нь Манжуур хотноо анхны хурлаа амжилттай хийснээс хойш 1996 оны

5 сар, 2000 оны 12 сар, 2002 оны 5 сар, 2004 оны 2 сард уг хуралдааныг нийт 5 удаа зохион байгуулсан байна. Улаанбаатар хотноо мөн “Өвөр Монголын экспорт, импортын барааны үзэсгэлэн болон эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл”-ийн худалдааныг 1996, 1999 онд тус тус амжилттай хийсэн байна.

1997 онд Монгол Улсын Гадаад харилцааны яамны Гадаад худалдааны газрын дарга Болдбаатар тэргүүтэй эдийн засгийн төлөөлөгчдийн бүлэг манай оронд; 1998 оны 5 сард Ван Фэн чи дэд тэргүүлэгчтэй ӨЗО-ны эдийн засгийн төлөөлөгчдийн бүлэг Монгол Улсад; 1998 оны 12 сард Ерөнхийлөгч Н.Багабанди, 2001 оны 1 сард Ерөнхий сайд Н.Энхбаяр манай оронд; 2002 оны 5 сард ӨМӨЗО-ны Байнгын дэд тэргүүлэгч Юе Фү хун тэргүүтэй төлөөлөгчид, 2002 оны 8 сард ӨМӨЗО-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны танхимын дэд дарга Гао Шяо фэн тэргүүтэй төлөөлөгчид; 2003 оны 7 сард ӨМӨЗО-ны Худалдааны хэрэг эрхлэх танхимын дарга Бай Дүнь тэргүүтэй төлөөлөгчид, 2004 он 10-р сард ӨМӨЗО-ны тэргүүлэгч Янжин тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад тус тус айлчилж Монгол Улсын төр, засгийн удирдлага болон холбогдох яам агентлагийн дарга нартай уулзаж, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх тухай олон талаар ярилцаж, зохих гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж, хэрэгжүүлж ирсэн явдлаас үзэхэд манай хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа тогтвортой, үр дүнтэй, эрүүл саруул хөгжиж байхын тод баримт болж байна.

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2003 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1387.5 сая ам.долларт хүрснээс импорт 787.3 сая ам.доллар, экспорт 600.2 сая ам.доллар болжээ. Нийт бараа эргэлт өнгөрсөн оныхоос нь 14.2 хувиар, түүний дотор экспорт 14.5 хувь, импорт 14.0 хувиар тус тус өссөн явдал нь манай хоёр орны хойшдын хамтын ажиллагаанд таатай нөхцөл бололцоог өгч байна.

III. ӨМӨЗО болон Монгол Улсын эдийн засаг хамтын ажиллагааны дунд оршиж байгаа гол асуудал

1. Сүүлийн жилүүдэд Монгол Улс нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээгээ бүх талаар гадагш нээснээс барууны хөгжсөн орнууд ч өөрийнхөө орчин үеийн шилдэг техник мэргэжил болон сайн чанарын бараа бүтээгдэхүүнээ түшиж, Монголын зах зээлд хүчтэй орж ирсэн байна. Монгол Улсын зах зээл нь нэгэнт Америк, Япон, Өмнөд Солонгос, Хятад, Сингапур зэрэг улс орны олон талт өрсөлдөөний талбар болж хувирлаа. Одоохондоо манай улсын нэлээд олон төрлийн барааны чанар чансааг мэргэжлийн түвшин нь хөгжсөн улсуудтай харьцуулбал бас нэлээд зөрөөтэй байж, өрсөлдөх хүч чадал

нь бас байна. Иймээс барааны чанарыг сайжруулах, хуурамч барааг Монголын зах зээлд орохыг эрс хориглох, манай орны барааны нэр хүндийг дээшлүүлэх, Монгол буюу олон улсын зах зээлд өрсөлдөх хүчин чадлыг эрчимжүүлэх шаардлагатай юм.

2. Монгол Улс нь ӨМӨЗО-той хил залган оршдог болохоор нутаг дэвсгэрийн давуу талтай, эдийн засгийн харилцан нөхвөрлөх боломж сайтай орон юм. Сүүлийн жилүүдэд манай орны томоохон пүүс компаниуд Монголын зах зээлд нэлээд хөрөнгө оруулалт хийж ирсэн боловч үр ашиг нь сайн биш байна. Үүнд манай талаас шалтгаалах хүчин зүйл байгаа боловч Монголын талд хөрөнгө оруулалтын таатай орчин хараахан сайн бүрэлдээгүй, Засгийн газрынх нь зохицуулалтын хүч сул зэргээс улбаалж манай хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг бүрмөсөн хамгаалж чадахгүй байдал оршсоор байна.

3. Хил худалдааны хязгаарлалт чанар болон Хятад, Монголын эдийн засгийн бүтцийн хувиралтаас болж, манай оронтой худалдаа наймаа хийж байгаа Монгол Улсын төрийн өмчийн том пүүс компани цөөн байдаг. Жижиг, дунд зиндааны аж ахуйн нэгж буюу хувь хүн давамгайлж байдаг тул хөрөнгө мөнгө дутмаг, эзэгнэлтийн хүч чадал тааруухан байдаг байдал харагдаж байна.

4. Хятад, Монгол хоёр улс нь хэдийгээр ДХБ-ын байгууллагын гишүүн орон боловч хоёр талын худалдаа наймааны хооронд ямар нэгэн маргаан гарвал Олон улсын хуулийн дагуу асуудлаа шуурхай шийдэж чадахгүй бэрхшээл заримдаа гарсаар байна.

5. Монгол Улсын уул уурхайн эх баялгийг хамтран нээх ашиглах тал дээр геологи хайгуулын ажлын явц удаан, уулын хийгдсэн зарим материал нь хуучирснаас хайгуул хийх, нээн ашиглахад баталгаа муутай, олборлох эрхийн бичгийнх нь дийлэнх хувь нь хүний гарт байдаг тул хамтран ажиллахад нэлээд их хүндрэлтэй байдаг.

6. Ашигт малтмал олборлох орчин тойрны дэд бүтцийн хөгжил муу, усан хангамжийн нөхцөл тааруухан байдаг тул хөрөнгө оруулалтын өртөг өндөр гардгаас манай орноос Монголд уул уурхайн салбарт идэвхитэй хөрөнгө оруулахад зарим талаар нөлөөлж байдаг.

IV. Хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай хэдэн санал

1. Хоёр талын дээд зиндааны удирдлагын харилцан айлчлалыг эрчимжүүлэн, найрсаг харилцааг гүнзгийрүүлснээр Хятад, Монгол хоёр улсын худалдааны хамтын ажиллагаанд таатай уур амьсгал бий болгоно.

2. Манай улсын Худалдааг дэмжих зөвлөлийн арбирт болон Монгол Улсын Худалдааны зөвлөлийн арбиртын байгуулагууд хоёр талын аж ахуйн нэгжийн эдийн засгийн маргаантай асуудлыг

шийдвэрлэхдээ шуурхай зөвлөлдөж байгаад шийдвэрлэх арга замыг хайж, хоёр талын аж ахуйн нэгжийн хоорондын маргаантай асуудлыг аль болох шийдвэрлэж, хоёр талын аж ахуйн хууль ёсны эрх ашгийг хамгаалбал зохино.

3. Хоёр талын хил худалдааны экспорт, импортын барааны бүтцийг зохицуулах явдлыг анхаарч, цаг тухайд нь үр дүнтэй арга хэмжээ авч байвал зохино. “Чанараар итгэл олж цаашид найдвартай хамтран ажиллах” стратегийг хэрэгжүүлж, хуурмаг бараа хил нэвтрэх үйл ажиллагаанд үргэлжлэн цохилт өгөх хэрэгтэй.

4. Угийн байсан зах зээлийн салбараа бэхжүүлсний үндсэн дээр шинэ зах зээл, том зах зээлийг идэвхитэйгээр нээн, эдийн засгийн хүч чадалтай аж ахуйн нэгжийг зохион байгуулж, Монгол Улсад хөрөнгө оруулалт хийхийн сацуу ӨМӨЗО-ны аж үйлдвэрийн онцлогтой өргөн хэрэгцээний бараа таваарыг экспортлох ажлыг удаашруулж болохгүй.

5. ӨМӨЗО-ны хилийн зарим хошуу сянь мах, махан бүтээгдэхүүн хадгалан боловсруулах нөхцөл сайтай бололцоог ашиглаж, Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн импортлох зах зээлийг зоригтойгоор нээх хэрэгтэй. Энэхүү ажлыг үр дүнд хүргэвээс манай орны Хөлөнбуйр, Улаанхад, Шилийнгол, Баяннуур, Алаша зэрэг аймгийн мах, махан бүтээгдэхүүн боловсруулах аж ахуйн нэгж өөрийнхөө давуу талаа ашиглах бүрэн бололцоотой юм.

6. Манай улсын баруун бүс нутгийг ихээр хөгжүүлэх стратегийн бодлоготой нягт уялдуулж, Дэлхийн худалдааны байгууллагын дүрэм болон олон улсын шаардлагад нийцсэн гаалийн баталгаат бүсийг Эрээн хотод идэвхитэй бэлтгэн байгуулж, Монгол Улсын Замын-Үүдийн чөлөөт худалдааны бүстэй хамтран хөгжихийг чармайх хэрэгтэй.

7. Хоёр тал харилцан үзэсгэлэн худалдаа гаргах тоо хэмжээгээ нэмэгдүүлэх, өөр өөрийн шилдэг бараагаа сурталчилж, эдийн засгийн үр ашгаа дээшлүүлж, хоёр орны улс төр, эдийн засаг, соёл боловсролын харилцаагаа улам гүнзгийрүүлбэл зохино.

Ашигласан материал

1. Өвөр Монголын Худалдаа Хэргийн Танхимаас хангасан тоо баримт
2. Мөн тэнд
3. Мөн тэнд